

Э. Пунцаг  
Ц. Бавуудай

### ХЯТАД ДАХЬ «5-Р САРЫН 4-НИЙ» ХӨДӨЛГӨӨНИЙ ИМПЕРИАЛИЗМЫГ ЭСЭРГҮҮЦСЭН ШИНЖ ЧАНАР

1917 онд Орос оронд ялсан аугаа их Октябрийн хувьсгалын ач нөлөөгөөр дэлхийн бусад орнуудын нэгэн адил дорно зүгийн улс орон, түүний дотор империализмын дарлалд оршиж байсан хагас колонийн Хятад оронд үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн хүчтэй өрнөсөн юм. Энэ үед Хятадад үндэсний аж үйлдвэр харьцангуй хурдан хөгжиж, түүний хирээр ажилчин анги, хөрөнгөтөн хоёрын хоорондохь ангийн тэмцэл хурцдаж байв.

Үүний зэрэгцээгээр хятадад ноёрхлоо тогтоох гэсэн гадаадын империалист хүч, юуны өмнө Японы милитарист бүлэглэлийн эзэрхэг түрэмгий, бодлого хятадын ард түмний зүй ёсны дургүйцэлтэй тулгарч иржээ. Ийнхүү хятадын ард түмэн дотоодын цэрэг-феодалын дэглэм, гадаадын империалист хүчний эсрэг явуулах улс төрийн тэмцлийн урьдчилсан нөхцөл бүрэлдэхэд нь ялгуулсан Октябрийн зам амьд үлгэр жишээ болсон билээ.

Хятадын 1919 оны «5-р сарын 4-ний» хөдөлгөөн нь дорно зүгт Октябрийн туяа туссаны шинж тэмдэг, хятадад марксизм нэвтэрч хятадын ажилчин анги цогцлон бүрэлдэж улс төрийн намаа байгуулан феодал ба империализмын эсрэг тууштай тэмцэх замд орсны дохио болсон нь түүхийн бодит үнэн юм. Хөдөлгөөний нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн хамгийн онцлог шинж нь империализмыг эсэргүүцэж шинэ залуу Зөвлөлт Орос Улсыг талархан дэмжсэн явдал билээ.

«5-р сарын 4-ний» хөдөлгөөн нь «дэлхийн хувьсгалын уриа, оросын хувьсгалын уриа, Лениний урианы хариуд төрлөө» гэж Мао Зэдүн ч гэсэн тухайн үедээ хүлээн зөвшөөрч байжээ.

Гэтэл Хятадын өнөөгийн эрх баригчид «5-р сарын 4»-ний хөдөлгөөний гол үзэл санаа буюу тухайлбал, Октябрийн социалист хувьсгалын шууд нөлөөний дор үүсч түүнийг талархсан бодит баримтыг зориуд үгүйсгэж, хөдөлгөөний япон болон империализмыг бүхэлд нь эсэргүүцсэн шинж чанарыг нь маш бүрхэгдүүлж бараг тойрон өнгөрч байна.

Хөдөлгөөний империализмыг эсэргүүцсэн гол шинж чанарыг үгүйсгэх ажил «Соёлын хувьсгалаас» эхлэн дэс дараатай явагдсаар байна. Хэрэв «соёлын хувьсгалын» үед улаан хамгаалагчдыг «бид 5-р сарын 4-ний хөвгүүд» гэж нэр зүүлгээд хятадын нийгмийн дотоод дахь маоизмын эсрэг талынхныг залхаан цээрлүүлэхэд дайчилж байсан бол одоо дотоод бодлогын гол зорилт болгосон 4 шинэчлэлтэд «гарамгай» оролцохыг 5-р сарын хөдөлгөөний үед гарсан «шинэ соёл», «шинжлэх ухаан», «ардчилал» гэх мэт зарим нэгэн лоозонтой хүчээр холбон уриалж байна. Хятадад ХХ зуунд «ухамсрыг чөлөөлөх гурван удаагийн аугаа их хөдөлгөөн»<sup>1</sup> өрнөсний эхнийх нь «5-р сарын 4-ний хөдөлгөөн гэж одоо Бээжингийн удирдагчид үзээд түүнийг «улс үндэстний ухамсрыг феодалын үзэл суртлаас ангижруулж Хятадын ард түмний үндэсний ухамсар дээшлэхэд дэм нөлөө үзүүлсэн» гэдэг талыг нь нэгдүгээрт тавиад Хятад-Японы нууц хэлэлцээр болон Версалийн гэрээг зсэргүүцсэн, өөрөөр хэлбэл империа-

<sup>1</sup>«Жэньминь жибао» 1979. V. 7.

лизмыг эсэргүүцсэн шинж чанарыг нь аль болохоор орхигдуулж, түүнийг дотоод асуудалд нялзаан бүрхэгдүүлж байна. Уг хөдөлгөөний 60 жилийн ойд зориулан Хятадын нийгмийн ухааны Академийн дэд ерөнхийлөгч Жоу Ян хийсэн илтгэлдээ<sup>1</sup> уг хөдөлгөөн Хятадад марксизм-ленинизм түгэн дэлгэрч ХКН-ыг үүсгэн байгуулах нөхцөл бүрдэхэд үзүүлсэн шийдвэрлэх нөлөөг үгүйсгэж чадаагүй боловч «марксизм-ленинизм бол Хятадын бодит байдалд нийцэхгүй гадаадын суртал байсан юм» гээд марксизм-ленинизмыг «хятадчилах» зорилтыг Мао Зэдүн 1941 онд дэвшүүлж ХКН-ын интернационалч хэсгийн эсрэг, Коминтерны эсрэг явуулсан Жэнфэн буюу «намын ажлын арга барилыг цэгцлэх хөдөлгөөн» шийдвэрлэсэн гэж үзжээ. «5-р сарын 4»-ний хөдөлгөөнийг ингэж 40-өөд оны жэнфэнтэй болон одоогийн явуулж байгаа «ухамсрыг хамжлагаас чөлөөлөх хөдөлгөөн»-тэй тус тус ижилсэж байгаа нь үнэн хэрэг дээрээ «5-р сарын 4»-ний хөдөлгөөний түүхийг гуйвуулж түүний хувьсгалт уламжлалыг дотоод бодлогоо хэрэгжүүлэхэд ашиглах, алс утгаараа империализмыг эсэргүүцэхэд биш харин марксизм-ленинизм, пролетарийн интернационализм, социализм, коммунизмын эсрэг чиглүүлж буй хэрэг юм. Энэ нь 1979 оны 5-р сарын 3-нд уг хөдөлгөөний 60 жилийн ойн хурал дээр ХКН-ын Төв Хорооны дарга Хуа Гофэний хэлсэн үгэнд Октябрийн хувьсгалын тухай ганц ч үг байхгүй ба мөн орчин үеийн империалист хүчинтэй тэмцэх зорилтын талаар юу ч дурдаагүйгээс илэрхий байна. Үүгээрээ Хятадын өнөөгийн удирдагчид «5-р сарын 4»-ний хөдөлгөөн ба түүний дараахь үед Хятадын ард түмэн империализмыг эсэргүүцэж Зөвлөлт Оросыг талархсан түүхэн уламжлалыг мартагнуулах зорилго тавьж байна. Бээжингийн энэ бодлого нь АНУ, Япон мэт өрнө, дорнын империалист гүрнүүдийн эрх баригчдад таалагдахаар барахгүй сайшаагдаж байна.

АНУ-ын дэд ерөнхийлөгч Мондейл БНХАУ-ын засгийн газрын урилгаар Бээжинд албан ёсоор айлчлах хугацаандаа Бээжингийн Их Сургуулийн багш оюутнуудын өмнө 1979 оны 8-р сарын 27-нд хэлсэн үгэндээ: Америк-Хятадын харилцааны 80-аад оны төлөв, тэдгээрийн хоорондох хамтын ажиллагааны стратегийн чухал ач холбогдлыг онцлон заагаад Хятад- Америкийн өнөөгийн хамтын ажиллагааны эх суурь нь одоогоос 60 жилийн өмнө империализмыг эсэргүүцсэн хятадын оюутан залуучуудын «5-р сарын 4»-ний хөдөлгөөнөөр тавигдсан юм гэж цохон тэмдэглэжээ.<sup>2</sup> Үүнээс үзэхэд Бээжин дэх цэргийн эрхтний засгийн газар—АНУ хоёрын 1919 онд эх суурийг нь тавьсан хамтын ажиллагааны зарчим улиран өвлөгдсөөр өнөө хүртэл үргэлжилж байгаа нь илэрхий болж байна.

Дэлхийн I дайны төгсгөлд 1919 оны 1-р сарын 18-нд нээгдсэн Парисын энх тайвны бага хурлын үед АНУ-д Хятад ихээхэн найдвар тавьжээ. Учир нь АНУ-ын тэр үеийн ерөнхийлөгч В. Вильсоны 1918 оны 1-р сарын 18-нд тунхагласан 14 зүйлт «тунхаглал»-ын үзлээр «Лигинач» байгуулж түүгээр хэлэлцүүлэн хятадын нутаг дэвсгэрийг яваандаа бүрэн бүтэн болгох ба юуны өмнө бага хурлаар Германы эзэмшилд байсан Шаньдун мужийг Хятадад буцааж өгнө гэж найдварлаж Германы эсрэг дайнд оролцсон боловч Хятадын энэ найдвар талаар болж бага хурал Шаньдунд байсан Германы концессийг Японд шилжүүлэх шийдвэрийг 1919 оны 4-р сард баталжээ. (АНУ үнэн хэрэг дээрээ Шаньдун мужийг Хятадад эгүүлж өгөхгүй, харин «олон улсын хяналт» тогтоож өөртөө ашиглахыг хичээж байжээ). Энэ үеийн АНУ-ын бодлогын онцлог нь бол хувьсгалт Оросыг ганцаардуулах, Хятадаас Японыг шахан зайлуулж өөрийн нөлөөг Хятадад улам бэхжүүлэх «нээлттэй хаалгын» бодлого явуулах, Хятад дахь үндэсний эрх чөлөөний тэмцэлд саад учруулахад оршиж байлаа. Товчоор хэлэхэд ийм нөхцөлд АНУ-Хятадын

<sup>1</sup> Мөн сонин.

<sup>2</sup> «Бээжин радио», 1979. 8. 28.

«хамтын ажиллагааны» эх суурь тавигдсан ажээ. Үнэн хэрэг дээрээ АНУ- Хятадын одоогийн «хамтын ажиллагааны» хэлбэр төрх нь хэнд ч гэсэн тэр үеийг санагдуулж болох юм. АНУ-ын империалистууд «5-р сарын 4»- ний хөдөлгөөний (1919) үед ч хятадыг өмөөрөгч нүүр царай гаргаж байсан бол «5-р сарын 30»-ны хөдөлгөөний (1925) үед ч тийм нүүр царай гаргаж байсан.<sup>1</sup> Гэтэл аль ч үед нь харгис үүрэг гүйцэтгэснийг хятадын шинэхэн түүх гэрчилж байна.

Ихэтуаний бослогыг дарсны дараа 1901 онд Германы хүчээр булаан авч эрх дархаа тогтоосон хятадын салшгүй хэсэг 36 сая хүн амтай Шаньдун мужийг 1919 оны Парисын бага хурлаар буцааж авах шударга шаардлагыг Бээжингийн засгийн газар болон Кантоны хувьсгалт засгийн газрын хамтарсан төлөөлөгчид ард түмнийхээ шаардлагын дагуу уг бага хуралд тавьсан боловч империалист гүрнүүд Японы «Хятад дахь онцгой сонирхол», тэр талаархи АНУ-Японы хэлэлцээрийг үндэслэн Шаньдун дахь Германы бүх эрх мэдлийг Японд шилжүүлсэн нь Хятадын бүрэн эрх тусгаар тогтнолыг хортойгоор зөрчсөн империалист гүрнүүдийн илэрхий хуйвалдаан байв. Японы империалистууд бүр 1914 оны намар Шаньдун мужид цэргийн хяналт тогтоогоод 1915 оны 5-р сард Юань Шикайн засгийн газарт улигт «21 зүйлийн шаардлага» тулган хүлээлгэж 1917—1918 онд Японы талыг баригч Дуань Цижуйн засгийн газарт (энэ засгийн газар 1916 оны 6-р сараас 1918 оны 110-р сар хүртэл тогтож байв) төрөл бүрийн зээл олгох замаар эдийн засаг, улс төрийн байр сууриа хятадад улам бэхжүүлж байв. Японы империалистууд үүнийхээ зэрэгцээгээр Шаньдун муж дахь Германы бүх эрх мэдлийг ямар ч болзолгүйгээр Японд шилжүүлэх шаардлагыг Парис-д 1919 оны 1-р сарын 22-нд эхлэн албан ёсоор тавьжээ.

Ийм учраас «5-р сарын 4»-ний хөдөлгөөн нь юуны өмнө японы империалистууд болон түүний гар хөл болсон үндэсний урвагч Дуань Цижуйн бүлгийн эсрэг чиглэж байв. Харин Парисын бага хурал 1919 оны 4-р сарын сүүлчээр Шаньдун мужид эдлэж байсан Германы бүх эрх мэдлийг Японд шилжүүлэх (Версалийн гэрээний 156—158-р зүйл) болсон мэдээ нь хөдөлгөөний шууд шалтаг болж 1919 оны «5-р сарын 4»-нд Тяньаньмэний талбайд нийслэлийн 13 дээд, дунд сургуулийн 5 мянга гаруй оюутан сурагчид «Үндэсний бүрэн эрхээ хамгаалая!», «Шаньдунд эрхээ сэргээе!», «21 шаардлагыг хүчингүй болгоё!», «үндэсний урвагчдыг шийтгэгтүн!» гэх мэт лоозонтойгоор цуглаан хийж сүрт жагсаал үйлджээ. Тэд Бээжинд байсан империалист гүрнүүдийн элчин сайдын яамдад эсэргүүцэл илэрхийлэхийн хамт японтой байгуулсан боолчлолын гэрээнд гарын үсэг зурсан зарим сайд, түүний дотор Бээжингийн засгийн газрын сайд Цао Жулины байрыг шатааж, Японд сууж байсан Хятадын элчин сайд Чжан Цзунсянийг барьж зоджээ. Хятадын эрх баригчид хөдөлгөөнд оролцогчдыг цэрэг цагдаагийн хүчээр хөөн тарааж баривчилсан ба 30 гаруй хүнийг хатуу ширүүнээр зодож жанчжээ.<sup>2</sup> Гэвч хөдөлгөөн намдсангүй харин «Бээжингийн оюутан сурагчдын нэгдсэн холбоо»-г байгуулж тэндээс нийслэл дэх империализмын эсрэг хөдөлгөөнийг удирдан зохион байгуулж засгийн газарт тавих шаардлагыг улам чангалав. Ийм учраас засгийн газар баривчилсан оюутныг суллаж, зарим сайдуудыг огцруулсан нь хөдөлгөөний хоёр дахь үеийн амжилт болсон бөгөөд энэ үед хөдөлгөөн Шанхай, Кантон зэрэг хотуудад дэлгэрч худалдаачид, ажилчдын жагсаал, цуглаан олширч Шанхайд нэхмэлийн зэрэг үйлдвэрийн ажилчид, төмөр замчид ажил хаялт зарлаж түүнд 6-р

<sup>1</sup>Пын Мин. История Китайско-Советской дружбы. М., 1959, 148-р тал.

<sup>2</sup>В. П. Илюшечкин. Антиимпериалистическое движение «4 мая» 1919 г в Китае.—Журн. «Проблемы Дальнего Востока» 1979. М., № 2. 149-р тал.

сарын эхээр 60-70 мянган ажилчид оролцох болжээ. Энэ үед хөдөлгөөн нь 20 гаруй муж, район, 100 гаруй хот сууринг хамарчээ. Босогчид ажил хаялтыг зохион байгуулах хороо байгуулж нилээд боловсронгуй дайчин төлөвлөгөөтэй ажиллаж байв. Ийнхүү «5-р сарын 4»-ний хөдөлгөөн нь оюутан, худалдаачид, ажилчид оролцсон Хятадын түүхэнд анхны улс төрийн томоохон сүрт жагсаал, бүх орныг хамарч империализм ба феодализмыг эсэргүүцсэн хөдөлгөөн болон өрнөж Хятадын ард түмний эрх ашигт харшилсан Версалийн гэрээнд Хятад улс гарын үсэг зурах явдлыг зогсоож чадсан ялалтаар өмнөө тавьсан гол зорилтоо хангажээ. Версалийн гэрээнд гарын үсэг зурах ёслол болсон 6-р сарын 28-нд Парис-д байсан Хятадын төлөөлөгчдийн байрыг Францад сууж байсан хятад ажилчид оюутнууд бүслэн хаажээ. Энэ үед гэрээнд гарын үсэг зурахыг хориглосон цахилгаан утас 1000 гаруй газар байгууллагаас ирж, Хятадын төв хотуудад «5-р сарын 4»-ний хөдөлгөөн үргэлжилж байсан учир төлөөлөгчид Версалийн гэрээнд гарын үсэг үл зурах тухайгаа мөн өдөр (6-р сарын 28-нд) мэдэгджээ. В. И. Ленин 1919 оны 11-р сарын 22-ны өдөр Дорнодахины ард түмний коммунист байгууллагуудын бүх Оросын 2-р их хурал дээр тавьсан илтгэлдээ тухайн үеийн улс төрийн гол сэдэв бол Дорнодахины ард түмнээс империализмтэй хийх хувьсгалт тэмцэл болохыг чухалчлан зааж «тэдгээрийн хувьсгалт хөдөлгөөн нь олон улсын империализмын эсрэг манай Зөвлөлт Бүгд Найрамдах Улсын явуулж буй хувьсгалт тэмцэлтэй шууд холбоо тогтоосноор л сая амжилт олно» гэж заажээ.<sup>1</sup> Ийм холбоо тогтооход Зөвлөлт Орос улс бүр 1918 оны 12-р сарын 2-нд Бүх оросын төвийн гүйцэтгэх хорооны шийдвэр гаргаж хятадаас 1900 оны ихэтуаний бослогын төлбөрөөр Орос улсад ноогдох хувийг хэрэгсэхгүй болгох тухай болон түүнийг дэлгэрүүлж хятадын ард түмнийг хүч хөрөнгөөр түрээ барьж боолчилсон чанартай хоёр талын болон холбооны үүрэг бүхий нууц гэрээнүүдийг устгах зэрэг чухал заалт бүхий ЗСБНОУ-ын Ардын Комиссаратын Зөвлөлийн 1919 оны 7-р сарын 25-ны уриалга<sup>2</sup> чухал ач холбогдолтой болсон билээ. Энэ уриалгын эцэст Хятад хэрэв Версалийн гэрээний үед амссан хувь заяагаа давтахгүйгээр Оросын бүх ард түмний адил эрх чөлөөтэй болохыг хүсвэл түүний цорын ганц холбоотон болоод ах дүү нь Оросын ажилчин тариачин, түүний улаан арми гэдгийг мэдэх болог гэж шууд ил тодорхой хандан уриалжээ. Нөгөө талаар харилцан тэгш эрхийн үндсэн дээр гэрээ хэлэлцээ байгуулж харилцаа тогтоох санал дэвшүүлсэн зэрэг эдгээр чухал мэдээг Бээжингийн харгис засгийн газар ард түмнээсээ нуун дарагдуулснаар даруй 8 сар өнгөрсөн хойно буюу 1920 оны 4-р сарын 3-нд Хятадын хэвлэлд хагас дутуу гарчээ.<sup>3</sup> Дашрамд тэмдэглэхэд 1919 онд Зөвлөлт Оросын засгийн газраас Монголын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрч илгээсэн ижил утга бүхий уриалга нь бас л дарагдан саатсаар 1920 оны 7-р сард нийслэл Хүрээнд гардуулагджээ<sup>4</sup>.

Эзэрхэг түрэмгий нарын Версалийн гэрээ, түүний системээс үндсээрээ ялгаатай Зөвлөлт Оросын засгийн газрын энэхүү олон улсын шинэ маягийн харилцаа-энх тайванч, энэрэнгүй ёсны гадаад бодлогын чиг шугам, нөгөө талаар Зөвлөлтийн Алс Дорнодод интервенци болон цагаантны үлдэгдлийг бут цохисон явдал Зөвлөлт Орос ба Дорнодахины ард түмний хооронд шууд хэлхээ холбоо тогтооход нааштай нөлөөллөө. Энэ үед империализмын нүүр царай Версалийн гэрээ, Вашингтоны бага

<sup>1</sup>В. И. Ленин. Сочинения, изд. IV, т. 30, 130-р тал.

<sup>2</sup> Советско-Китайские отношения (1917.—1957), М., 1959, док. № 9, 43—45-р тал.

<sup>3</sup>Ленинская дипломатия мира и сотрудничества. М., 1965. 150-р тал.

<sup>4</sup>Монгольский сборник. М., 1959, 107-р тал.

хурлын шийдвэр зэргээр ил тод харагдаж байв. Хуурамч «ардчилал», «энх тайван», «хүнлиг ёс»-ыг тунхагласан В. Вильсоны программыг «5-р сарын 4»-ний хөдөлгөөний нэг удирдагч Ли Дажао «хий буудлага» гэж нэрлээд империалистуудын бодлогыг эсэргүүцэхийг уриалжээ»<sup>1</sup> Зөвлөлт Орос Улс, түүний туршлагад хандах хандлага бол нилээд өргөн бөгөөд үнэн чанартаа социализм, коммунизмын тухай асуудал болон хувирчээ. Үүнтэй уялдан Хятад дахь «5-р сарын 4»-ний хөдөлгөөн ба түүний дараахь үед уг хөдөлгөөний үзэл суртал, зохион байгуулалтыг манлайлагч сэхээтний бүлэг дотроо ялгарч зарим нь хөрөнгөтний реформист, дийлэнх олонхи нь янз бүрийн социалист урсгал болж сүүлдээ гоминдан болон нэгэн хэсэг нь коммунистуудын эгнээнд шилжсэн байна.

Хятадад империализмыг эсэргүүцсэн хөдөлгөөний үед социалист, хувьсгалт шинэ үзэл санаа нэвтрүүлэх үзэл суртлын тэмцэлд чухал үүрэг гүйцэтгэсэн дэвшилт сонин хэвлэлүүдийн нэг болох «Мэйчжоу пин- лунь»-г («Долоо хоногийн тойм») Бээжингийн Их сургуулийн нийгмийн ухааны факультетын даамал Чэнь Дусю (39 настай), мөн их сургуулийн ахлах номын санч Аи Дажао ,(30 настай) нар эрхлэн гаргасан бөгөөд тэдний сэтгүүлийн хуудсаар дамжиж шинжлэх ухааны социализмын онол, практик, Октябрийн хувьсгалын дэлхий дахины ач холбогдол зэрэг марксизм-ленинизмын гол гол асуудлууд анх удаа хятад хэлээр нэвтэрсэн байна. Хэрэв «Синьциннянь» («Шинэ залуучууд») сэтгүүлийн 5-р сарын дугаарт Ли Дажаогийн «Ертөнцийг үзэх миний марксист үзэл» гэх мэт олон өгүүллүүд хэвлэгдэж байсан бол хөдөлгөөний нэг удирдагч Чэнь Дусю «Мэйчжоу пинлунь» сэтгүүлийн 1918—1919 онд гарсан 37 дугаарт 16 тэргүүнийг оролцуулан нийт 22 өгүүлэл бичжээ.<sup>2</sup> Харин хөдөлгөөний нэгэн зүтгэлтэн Бээжин их сургуулийн залуу профессор, философч Ху Ши, буюу Ху Шижи (1891 —1962) (АНУ-д цол хамгаалж тэр үед Америкт ихэд дэлгэрч байсан прагматизм, түүний нэг хувилбар болох инструментализмын философийг номлогч Джон Дьюи (1859—1952)-ийн шавь. -зох.) хэдийгээр дээрх сэтгүүлд хамтран зүтгэдэг боловч үзэл суртлын хувьд цэвэр прагматист хэвээр үлдэж социализмын үзэл санаа, коммунист намын эсрэг тэмцэж тэр ч байтугай «5-р сарын 4»-ний хөдөлгөөн бол «Вильсонизм»-ын үр дүн гэж тайлбарлахыг оролдсоноороо империализмыг шууд өмгөөлөгч болохоо харуулжээ.<sup>3</sup>

«5-р сарын 4»-ний хөдөлгөөн нь ангийн бүрэлдэхүүний хувьд оюутан, сэхээтэн, хөрөнгөтөн ба жижиг хөрөнгөтөн, ажилчин оролцсон хөрөнгөтний ардчилсан хөдөлгөөний шинжтэй<sup>4</sup>, өмнөө тавьсан гол лоозон нь хязгаарлагдмал боловч хятадын ажилчин анги<sup>5</sup> анх удаа улс төрийн тэмцэлд босч Хятад орныг гадаадын империализмын ноёрхол, дотоодын феодал-цэргийн эрхтний харгислалаас чөлөөлөхөд чиглэгдсэний хувьд чухал түүхэн үүрэг гүйцэтгэжээ.

«5-р сарын 4»-ний хөдөлгөөнд гадаадад сурч байсан хятад оюутнууд идэвхтэй оролцжээ. Үүний нэг жишээ нь тэр үед Японы Васэда-гийн их сургуульд сурч байсан ирээдүйн интернационалч коммунист залуу Пэн Бай оролцсон хятад оюутны жагсаал болно. Тэд 1919 оны 5-р сард «Үн-

1Ли Дачжао. Избранные статьи и речи. М., 1965.

2«Китай: Поиски путей социального развития», М., 1979. 101-р тал.

3Мөн номд тодорхой буй.

4В. П. Илюшечкин. дурдсан зохиол.

5«5-р сарын 4»-ний хөдөлгөөнд бараг 100 мянга шахам ажилчид оролцжээ. («Новейшая история Китая» М., 1972, 58-р тал).

дэсний гутамшигийг арилгагтун!». «Циндао-г эгүүлэн авагтун!», «Милитаризм сөнөтүгэй!» гэсэн лоозонтойгоор Токио дахь гадаадын элчин сайдын яамдын гудамжаар жагсаал үйлдсэн ба жагсагчдыг японыг цагдаа хүч хэрэглэн тараахад Пэн Бай шархдаж явжээ. Энэ үеийн Хятадын үнэхээр үндэсний гутамшиг болсон зүйлийн нэг бол бидний ойлголтоор Шаньдун муж зэрэг нутаг усыг нь дараа дараалан дээрэмдсэн Герман, Японы харгис засгийн газар, тэдгээрийн ард хуурамч амлалтаар сэтгэл хуурч сэм завшихыг хичээсэн АНУ-ын империализмтэй тэмцэхийн оронд харин тэдээртэй тухайлбал японтой нууц хэлэлцээр байгуулан Зөвлөлтийн эсрэг интервенцид орсон явдал юм.

Бээжингийн харгис засгийн газар 1918 оны хавраас эхлэн атаман Семеновын дээрэмчдийг Манжуур, умард Хятадад үүрлүүлж, ар талыг нь тэтгэж байсны зэрэгцээгээр 1918 оны 5-р сарын 16-нд Японтой нууц хэлэлцээр байгуулж,<sup>1</sup> Сибирь нутагт заналхийлж байгаа «Австри-Германы аюул» гэгчийн эсрэг цэргээ явуулахаар тохиролцсон ба тэр ёсоор Сибирьт Японы армийн хойноос цэргээ оруулаад гагцхүү интервенци цохигдож АНУ, Англи, Франц улсууд Зөвлөлтийн Алс Дорнодоос цэргээ татахтай зэрэг 1920 оны 8-р сард Зөвлөлт Оросын эсрэг «хамтран хамгаалах» тухай Японтой хийсэн хэлэлцээрээ орхиж цэргээ татаж эхлэжээ.

Хятад нь ийнхүү 1918—1920 онд хэрэг дээрээ шинэ залуу Зөвлөлт Орос ба хөрш зэргэлдээ Монголын эсрэг Сибирь, Алс Дорнодын чиглэлээр хийсэн империалист интервенцид идэвхтэй оролцжээ. Энэ бол Зөвлөлт Орос ба Монголын эсрэг үйлдсэн зэвсэгт интервенци байв.

Хятад-Японы (1918—1919 оны) нууц гэрээ хэлэлцээрүүдтэй уялдан «Монголын асуудал» гэгч Чита, Хүрээгээр зогсохгүй, Парис (1919) Вашингтоны (1922) олон улсын бага хурлуудаар хүртэл үе үе хөндөгдөж байжээ. Юуны өмнө дурдахад 1919 оны Хятад дахь империализмыг эсэргүүцсэн залуучууд, оюутны хөдөлгөөн нь Хятад-Японы дээрх онуудын нууц гэрээ хэлэлцээрүүдийг эсэргүүцсэн утгаараа монголын ард түмний талархлыг хүлээж монголчуудын сэтгэл санааны дэмжлэгийг олжээ. Учир нь тэдгээр гэрээ хэлэлцээр ёсоор Монгол нь тэр үед хөрш орнуудаараа хүлээн зөвшөөрөгдөөд хэдэн жилийн нүүр үзсэн (1911 оноос хойш) богд хаант төрөө устгуулж наандаж тусгаар тогтнолоо алдах ба цаашилбал Зөвлөлт Оросын эсрэг дайны түшиц газар болон хувирах аюул тулгарч байв. Юу гэвэл, 1918 оны 5-р сарын 16-нд Дуань Цижуй хятадын цэргийн харгис эрхтнүүдийн түлхээсээр гарын үсэг зурсан Япон-Хятадын цэргийн хэлэлцээ ба түүний нууц хавсралт нь Японы 60 мянган цэргийг Манжуурын хойт талаар оруулж байрлуулах, нийслэл Хүрээ (Урга)-нээс Чита хүртэл харуул хамгаалалтанд Хятадаас 7 мянгаас доромжгүй цэрэг гаргах, Манжуурын нутагт үүрлэсэн цагаантны бүлгээс цэрэг элсүүлэх, шаардлагатай үед Хятадын цэрэг Хүрээнээс Өвөр Байгалын чиглэлээр давших гэх мэт зүйлүүдийг багтаажээ. Японы засгийн газар Хятадын цэргийн зардалд зориулж зөвхөн 1918 оны 8-р сард хэлэлцээ ёсоор 20 сая иен өгчээ.<sup>2</sup> Хятадын цэрэг ийнхүү 1918 оноос эхлэн Хүрээ, Хиагтад хүрэлцэн ирж олон цөөнөөр хуарагнах болсон нь «холбоотонд туслах үүргийнхээ ёсоор Австри-Германы аюулыг эсэргүүцэх», «большевизмын аюулаас хамгаалах» эсгүүл «хил хязгаар хамгаалах» гэдэг янз бүрийн нэрийн дор нэвтэрч байсан боловч уг зорилго нь Монголыг хувааж Хятадад хүчээр хавсарган нийлүүлэх, улмаар империалист Японтой хавсран Зөвлөлт

1История внешней политики СССР. ч. I (1917—1945), М., 1966, с. 148.

2Б. Г. Сапожников. «Китай и Советский Дальний Восток» (1918—1922) («Вопросы Истории», М., № 4, 1976, 92—97-р тал.)

Оросын зүүн хязгаараас дайралт хийх зорилготой Хятад-Японы гэрээт цэргийн хэсэг байжээ.

Японы милитаристууд Октябрийн хувьсгалын дараагаар цагаантны үлдэгдэл атаман Семеновыг ашиглан Монголыг булаан эзлэхийг бодсон боловч цагаантан улаан армид бут цохигдож Японы гар хөл болсон Хятадын Аньфу намын харгис генерал Сюй Шужэн 1919 оны намар Монголд үлэмжхэн цэрэгтэй, нэвтрэн орж 12-р сарын 7-нд «автономи»-аас сайн дураар татгалзах тухай актанд Монголын засгийн газрын таван яамны сайдын гарын үсэг зуруулж авчээ. Энэ бол «Орост хаант засаг унасныг ашиглан Гадаад Монголыг өөртөө бүрмөсөн захирах гэсэн Хятадын засгийн газрын шийдвэр<sup>1</sup> болох тухай академич Б. Ширэндэв бичсэн байдаг. Хятадын цэрэг нийслэл Хүрээг эзэлж аваад хүн амыг айлган сүрдүүлж, үндэсний сургууль соёлын газрыг хааж хятадын дарангуй цэргийн эмнэлгийн салбар зэргээр солиод бас «Монгол улс» гэж ярьж, бичихийг хүртэл тушаан хориглож байжээ. Хятадын энэ бодлого нь «Орос улсын улаан намын хүмүүсийн» аюулаас болгоомжлох нэрийн дор Зөвлөлт Оросыг эсэргүүцэж. Монголыг богино хугацаанд хятад-чилах бодлого байсан нь 1919 онд Хүрээнд Баруун хойт хязгаарын хэргийг шийтгэх яам гэгчээс эрхлэн хэвлэж байсан (бүгд 153 дугаар) «Шо Фаны өдрийн сэтгүүл» («Хойт газрын сонин»)-ийн материалаас илхэн байна. Иймээс тэд «дарангуй» цэрэг гэж нэрлэгдэж ард олны дургүйцлийг хүргэж байсныг тусгаж 1915—1920 онд тэр үеийн Монголын үндэсний дэвшилт ардчилсан сэтгэлгээ бүхий шилдэг сэхээтэн-соён гийгүүлэгч нарын гаргаж байсан «Нийслэл Хүрээний сонин бичиг»-т «...газар орноо цагдах хамгаалах хэв ёсыг сахиулж, сэргэмжлэх нь чухамхүү улс орны хэрхэвч гэж үл болох дотоод эрх байсаар атал Дундад улсын цэрэг хил хязгаараар цөмрөн ороод нийслэл хотод шивээлэн сууж байгаа нь тусгаар тогтносон улс орны эрх хэмжээнд огт үл нийцэх зүйл мөн»<sup>2</sup> гэж эсэргүүцэн бичиж байжээ. Үүнээс хойш 1920—1921 онд хэвлэгдэн гарч байсан өөр нэгэн хэвлэл «Монголын үнэн»-нд бичихдээ: «Хятадын эзэрхэг харгисуудаас Монгол улс урьдаас нааш нэгхэн ч сайны зүйл үзсэнгүй, хойш ч үзэхгүй. Гагцхүү зүй нь монгол олон өөрсдийн зориг хүчнээн хамтатгаж элсэн босож, цэрэг хуралдуулан, зэр зэвсэг барьж Хятадын эзэрхэг шунахай дээрэмчдийг хөөн арилгахын» чухлыг цохон тэмдэглэж ард түмнийг үндэсний эрх чөлөөний хөдөлгөөнд дуудан уриалсан шүлэг нь:

Манай мандах замыг таслахыг хүсэгч  
Мангас мэт харгис хятад эзэрхэгүүдийг  
Илд мэсийн хүчээр эс хөөвөөс  
Язгуур Монгол улсын жаргах явдал  
Хаврын цасан мэт хайлан хоцрох, биш үү<sup>4</sup> гэжээ.

Үүний зэрэгцээгээр мөн сэтгүүлд: Монголын ард түмэн империализм, феодалыг эсэргүүцсэн хятадын ард түмний хөдөлгөөний өрнөлтийг талархан дэмжиж «Хятад улсын үнэхээр ардын засаг байгуулахыг эрмэлзэж байсан ардын аймаг лугаа барилдлага залгаж, ...Басхүү өмнө, дорно зүгээс ноёд баячууддаа дарлагдагч хятадын ардууд, Жан Золин,

<sup>1</sup> Б. Ширендыб. «История Монгольской Народной Революции 1921 года». (перевод с монгольского.) М., 1971, 111-р тал.

<sup>2</sup> Г. Дэлэг. «Монгол тогтмол хэвлэлийн түүхэн тэмдэглэл». УБ., 1965, 31—36-р тал.

<sup>3</sup> Ч. Жүгдэр. «XIX—XX зууны зааг дахь монголын нийгэм-улс төр, философийн сэтгэлгээний хөгжил», УБ., 1972. («Нийслэл Хүрээний сонин бичиг», 1920, № 103.)

<sup>4</sup> «Монголын үнэн» сонин № 3, 1920 оны 12-р сарын 20. («Монголын үнэн» сонин. УБ., 1971, эмхтгэлээс эш татав).

Чен И мэтийн харгисуудыг засгийн газраас ховх түлхэн устгахаар хүчилж байснаар тусалмуй»<sup>1</sup> гэж байхад Хятадад ч ардчилсан дэвшилт хэсгийн дуу хоолой чангарч Монголын ард түмний шаардлага тэмцлийг дэмжиж байсныг «Тун бао» сонин Монголын тусгаар тогтнолыг ч хүлээх хэрэгтэй гэж бичиж байсан явдал бас гэрчилнэ.<sup>2</sup>

Энэ үед Хятадын хөдөлмөрчид Зөвлөлт Оростой найрсаг хөршийн харилцаа тогтоохыг засгийн газартаа шаардах нь ихэсч байсан тул 1920 оны 9-р сарын 5-нд Бээжингээс генерал Жан Сылин тэргүүтэй төлөөлөгчид Москвад хүрэлцэн ирж Зөвлөлт-Хятадын хооронд хэлэлцээр байгуулан хэвийн харилцаа тогтоожээ. Хятадын төлөөлөгчдийг В. И. Ленин хүлээн авч Хятад, Зөвлөлт хоёр гүрнийг империализмын дарлалтай тэмцэх нийтлэг зорилго нэгтгэж байгаа учраас тэдгээрийн хоорондох харилцаа батжин бэхжинэ гэдэгт итгэж байгаагаа илэрхийлжээ.<sup>3</sup> 1921 онд Японы булаан эзлэгч интервентүүд, түүний гар хөл бологсдыг улдэн хөөж тусгаар тогтнолоо сэргээж мөн онд их Ленин, Сүхбаатар нарын санаачлагаар найрамдалт харилцаа тогтоож улмаар ардын төрөө мандуулахад Монголын ард түмэнд Зөвлөлт Орос ах дүүгийн тусламж үзүүлсэн билээ. Зөвлөлт Оросын сэтгэл харамгүй тусламжийн үрээр харийн дарлалаас үүрд чөлөөлөгдсөн Монголын ард түмэн одоо капитализмыг алгасан социализмын замаар амжилттай явж байна.

Хятадад ардын хувьсгал ялж 1949 онд БНХАУ байгуулагдсанд Монголын ард түмэн дэлхийн бух дэвшилт ард түмний хамт баяр хүргэн түүнтэй нэн даруй найрамдалт харилцаа тогтоож цаашид харилцан тэгш эрхийн үндсэн дээр энх тайван социализмын замаар хамтран ажиллах чин эрмэлзлэлээр дүүрэн байлаа. Чухам ийм л харилцаа манай орнуудын ард түмний эрх ашигт нийцэх байсан билээ. МАХН-ын Төв Хорооны нэгдүгээр нарийн бичгийн дарга, БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн дарга Ю. Цэдэнбалын хэлсэнчлэн—«Хятадын одоогийн эрх баригчид энх (тайван, намжмал байдлын заналт дайснуудтай нэгэн эгнээнд явж<sup>4</sup> Хятадын нийгэм-эдийн засгийг цэрэг дайны бэлтгэлд захируулж байна. Тэд ийм учраас, «5-р сарын 4»-ний хөдөлгөөний империализмыг эсэргүүцсэн мөн чанарыг зориуд огоорч Хятадын залуу үеийн тэрхүү хувьсгалт уламжлалын хурц үзүүрийг дав дээр дотоод бодлого тийш хандуулах, цаашилбал, даян дэлхийн энх тайван, социализм, коммунизмын эсрэг зүглүүлэхийг эрмэлзэж байна. Үүнийг «5-р сарын 4»-ний хөдөлгөөний 60 жилийн ойд зориулан нийтлүүлсэн өгүүлэлд залуучуудыг «дөрвөн шинэчлэлтэнд гар бие оролцохыг» заагаад Вьетнамын эсрэг дайнд «баатарлаг гавьяа байгуулсан» залуусын үлгэр жишээгээр ажиллахыг уриалсан явдал гэрчилж байна.<sup>5</sup>

Гэвч Хятадын олон сая залуучууд 60 жилийн өмнө гадаадын империализм ба дотоодын феодализмыг эсэргүүцэн босч байсны адил өнөөдөр харгис маоизмын нөлөөний дор империализмтай тэмцэхийн оронд холбоотон нь болсон Хятадын өнөөгийн удирдагчдын гадаад дотоод бодлогын чиг шугамыг эсэргүүцэн байна. Тухайлбал, 1976 оны 4-р сарын 5-нд Тяньанмэний талбайд болсон жагсаал, мөн 1979 оны 9-р сарын 13-ны өдөр болсон 3000 гаруй хүний эсэргүүцлийн цуглаан түүнээс хойш ч удаа дараа гарсаар байгаа тэмцэл хөдөлгөөн нь Бээжингийн дэглэмийг эсэргүүцэж байгаагийн тод илрэл юм. Энэ ч бас нөгөө талаар хя-

<sup>1</sup> Мөн хэвлэл. 43-р тал.

<sup>2</sup> «БНМАУ-ын түүх» гутгаар боть (Нэн шинэхэн үе) УБ., 1969, 67-р тал.

<sup>3</sup> «Документы внешней политики. СССР», т. III, 662-р тал.

<sup>4</sup> Ю. Цэдэнбал. «МАХН-ын Төв Хорооны 6-р бүгд хурал дээр хэлсэн үг», «Үнэн», 1979. 11. 20,

<sup>5</sup> Жэньминь жибао, 1979. V. 5.

тадын залуучуудын хувьсгалт уламжлалын билэг тэмдэг, тэдний гарт ирээдүйн социалист Хятадын хувь заяа оршихын билэг тэмдэг юм.

**Э. Пунцаг  
Ц. Бавуудай**

**АНТИИМПЕРИАЛИСТИЧЕСКИЙ ХАРАКТЕР  
ДВИЖЕНИЯ «4 МАЯ» 1919 г. В КИТАЕ**

**Р е з ю м е**

Статья посвящена 60-летию массового антиимпериалистического движения в Китае, явившегося первым откликом китайского народа на победу Великой Октябрьской Социалистической революции в России.

Весной 1919 г. в Китае началось массовое антиимпериалистическое движение, известное в истории под названием «Движение 4 мая». Участники движения, начатого политической демонстрацией 5000 студентов 13 различных учебных заведений Пекина, которых поддержали 60 тысяч рабочих 20 провинций и 100 городов Китая, требовали отстранения от власти министров-предателей, заключивших кабальные соглашения с империалистической Японией, чтобы восстановить право в Шаньдуне и защитить суверенитет страны. Неограничиваясь антияпонскими выступлениями, в целом движение носило ярко выраженный антиимпериалистический характер. Антиимпериалистический характер движения «4 мая» достиг своего апогея на его завершительном этапе, когда основным лозунгом участников движения стал «отказ от подписания Версальского мирного договора, ущемляющего национальный суверенитет Китая». Такова главная цель движения, которая была успешно достигнута.

Авторы статьи, отмечая об историческом значении антиимпериалистического движения «4 мая», особо подчеркивают, что это движение послужило важным рубежом для подъема национально-освободительной борьбы китайского народа против внутренней реакции и иностранного империализма и создало необходимые предпосылки для образования Коммунистической партии Китая. Далее они отмечают, что если «Вильсонизм», а равно и «Версальский мир» показали себя как демагогия, как империалистические заговоры в ущерб интересам нации и народов, в том числе народов Китая, в отличие от них Советская Россия последовательно проводила дружественную политику примером которой служит декларация СНК РСФСР от 25 июля 1919 г. в адрес правительства Южного и Северного Китая. Однако нынешнее руководство Китае не только не упоминает об этих исторических фактах, а полностью игнорирует воздействие Великого Октября на движение «4 мая».

Авторы критикуют попытки маоистов фальсифицировать историю антиимпериалистического движения «4 мая» в угоду своей нынешней реакционной политике блокирования с американским империализмом.

В статье затрагивается один из малоизученных до сих пор момент истории японо-китайской интервенции против Советского Дальнего Востока и Монголии в период между 1918—1920 гг., когда на основе китайско-японских тайных договоров и соглашений, китайские войска оккупировали Ургу и в декабре 1919 г. ими было ликвидировано богдохановское правительство Монголии. В этом смысле, как отмечают авторы, антиимпериалистический, в частности, антияпонский характер движения «4 мая» нашел поддержку и симпатию у монгольского народа, боровшегося за свободу и независимость против китайских колонизаторов.